

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨРӨЛЖСӨН
БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ БОЛОН ХЯЗГААРЛАЛТЫГ
ТОГТООХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэ журмын зорилго Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 25 дугаар зүйлийн 25.1-д заасны дагуу хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, хязгаарлалтыг тогтоох, хэрэгжүүлэхэд оршино.

1.2. Энэ журам нь Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хууль, Банкны тухай хууль, энэ журам болон бусад холбогдох хууль, тус хуулиудтай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн актаас бүрдэнэ.

1.3. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үйл ажиллагаандаа дараах зохистой харьцаа, хязгаарлалтыг мөрдөж ажиллана:

- 1.3.1. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцаа, түүнийг хамгаалах нөөц;
- 1.3.2. Хөрвөх чадварын зохистой харьцаа;
- 1.3.3. Гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа;
- 1.3.4. Төвлөрлийн эрсдэлийн зохистой харьцаа, Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан хязгаарлалт.

1.4. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк энэ журмын 1.3-т заасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, хязгаарлалтыг үнэн зөв тооцож, түүнд үнэлгээ, дүгнэлт хийх замаар үйл ажиллагаандаа учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүр авна.

1.5. Монголбанкны Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-д заасан гадаадын хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны хяналт шалгалт, зохицуулалтын талаар тухайн банкиг хянан зохицуулах эрх бүхий этгээдтэй байгуулсан харилцан ойлголцлын санамж бичигт энэ журамд зааснаас өөрөөр зохицуулсан бол харилцан ойлголцлын санамж бичгийг дагаж мөрдөнө.

**ХОЁР.ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ
ЗОХИСТОЙ ХАРЬЦАА, ТҮҮНИЙГ ХАМГААЛАХ НӨӨЦ**

2.1. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны эрсдэл даах чадварыг Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д заасан өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтээр үнэлж, нэгдүгээр зэрэглэлийн болон нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааг тогтооно.

2.2. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээг энэ журмын 2.6-т заасан нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийг 2.11-д заасны дагуу тохируулан, 2.13-т тодорхойлсон эрсдэлээр жигнэсэн активт харьцуулан тооцно.

2.3. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээг энэ журмын 2.5-д заасан өөрийн хөрөнгийг 2.11-т заасны дагуу тохируулан, 2.13-т тодорхойлсон эрсдэлээр жигнэсэн активт харьцуулан тооцно.

2.4. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний доод хувь хэмжээ 9, нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээний доод хувь хэмжээ 12 хувь байна.

2.5. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны нийт өөрийн хөрөнгө нэг болон хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийн нийлбэр байна.

2.6. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө дараах бүрэлдэхүүнтэй байна:

- 2.6.1. Хувьцаа (энгийн болон давуу эрхийн);
- 2.6.2. Нэмж төлөгдсөн капитал (энгийн болон давуу эрхийн);
- 2.6.3. Хуримтлагдсан ашиг, алдагдал;
- 2.6.4. Нөөцийн сан.

2.7. Энэ журмын 2.6.1-д заасан давуу эрхийн хувьцаа дараах нөхцөлийг хангасан байна:

- 2.7.1. Хугацаагүй;
- 2.7.2. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк ногдол ашиг тогтмол төлөх үүрэггүй;
- 2.7.3. Энэ журмын 2.21.2-д заасан хязгаарлалт хэрэгжих боломжтой;
- 2.7.4. Ногдол ашгаас өөр хэлбэрээр өгөөж төлөх бүтэцгүй;
- 2.7.5. Давуу эрхийн хувьцаа худалдан авах эх үүсвэр нь хууль ёсны үйл ажиллагаанаас бүрдсэн, татвар төлсний дараах орлого байна;

2.7.6. Энэ журмын 2.7.1-2.7.5-д заасан нөхцөлийг давуу эрхийн хувьцаа гаргах шийдвэр, холбогдох гэрээ, хэлцэлд тусгасан байна.

2.8. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө энэ журмын нөхцөлийг хангасан хувьцаанд хөрвөх эх үүсвэр болон хоёрдогч өглөгөөс бүрдэнэ.

2.9. Дараах нөхцөлтэй хувьцаанд хөрвөх эх үүсвэрийг хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөд оруулан тооцож болно:

- 2.9.1. 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай;
- 2.9.2. Нийт хугацаанд үндсэн төлбөрийн эргэн төлөлт хийхгүй;
- 2.9.3. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 7.2 хувиас буурсан тохиолдолд үл маргах журмаар энгийн хувьцаанд хөрвөх нөхцөлтэй;

- 2.9.4. Энэ журмын 2.21.4, 2.22.4-т заасан хязгаарлалт хэрэгжих боломжтой;
- 2.9.5. Хүү, өгөөж нь өсөн нэмэгдэхгүй (no step-up);
- 2.9.6. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк, банкны нэгдэлд оролцогч, банкны холбогдох этгээдийн хөрөнгийг барьцаалаагүй, эргэн төлөлтөд баталгаа, батлан даалт гаргуулаагүй;

2.9.7. Монголбанкнаас урьдчилан зөвшөөрөл авч хугацаанаас нь өмнө хэсэгчлэн эсвэл бүрэн буцаан төлж болох. Төлсний дараа хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк энэ журмын 2.19 дахь заалтаар тогтоосон нөөцөө хангасан байна;

2.9.8. Монголбанкнаас урьдчилан зөвшөөрөл авч хөрөнгө оруулагчийг сольж болно;

2.9.9. Хөрөнгө оруулагч нь хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны зөвшөөрлийн хууль тогтоомжоор тавигдаж буй шаардлагыг хангасан;

2.9.10. Энэ журмын 2.9.1-2.9.9-д заасан нөхцөлийг холбогдох гэрээ, хэлцэлд тусгасан байна.

2.10. Дараах нөхцөлтэй хоёрдогч өглөгийг хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөд оруулан тооцож болно:

2.10.1. 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай, хугацааны эцэст хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч харилцан тохиролцож энгийн хувьцаанд хөрвөх боломжтой;

2.10.2. Нийт хугацаанд үндсэн төлбөрийн эргэн төлөлт хийхгүй;

2.10.3. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцааг 5.4 хувиас буурсан тохиолдолд үл маргах журмаар энгийн хувьцаанд хөрвөх;

2.10.4. Энэ журмын 2.21.4, 2.22.4-д тусгасан хязгаарлалт хэрэгжих боломжтой;

2.10.5. Хүү, өгөөж нь өсөн нэмэгдэхгүй (no step-up);

2.10.6. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк, банкны нэгдэлд оролцогч, банкны холбогдох этгээдийн хөрөнгийг барьцаалаагүй, эргэн төлөлтөд баталгаа, батлан даалт гаргуулаагүй;

2.10.7. Монголбанкнаас урьдчилан зөвшөөрөл авч хугацаанаас нь өмнө хэсэгчлэн эсвэл бүрэн буцаан төлж болно. Ингэхдээ банк энэ журмын 2.19 дахь заалтаар тогтоосон нөөцөө хангасан байна;

2.10.8. Монголбанкнаас урьдчилан зөвшөөрөл авч хөрөнгө оруулагчийг сольж болно;

2.10.9. Хөрөнгө оруулагч хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны зөвшөөрлийн хууль тогтоомжоор тавигдаж буй шаардлагыг хангасан;

2.10.10. Энэ журмын 2.10.1-2.10.9-д заасан нөхцөлийг холбогдох гэрээ, хэлцэлд тусгасан байна.

2.11. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны өөрийн хөрөнгөд дараах тохируулгыг дараалуулан хийнэ:

2.11.1. Халаасны хувьцааг өөрийн хөрөнгийн харгалзах төрлөөс хасна;

2.11.2. Гүүдвилийг энгийн хувьцаанаас хасна;

2.11.3. Давуу эрхийн хувьцаа, түүнээс нэмж төлөгдсөн капиталын нийлбэр энгийн хувьцаа болон түүнээс нэмж төлөгдсөн капиталын нийлбэрийн 50 хувиас илүүгүй байна;

2.11.4. Програмаар хангамж, хойшлогдсон татварын авлагын нийлбэр нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн 10 хувиас хэтэрсэн бол хэтэрсэн хэсгийг нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс хасна;

2.11.5. Банк хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны өөрийн хөрөнгөд шууд болон гуравдагч этгээдээр дамжуулан байршуулсан хөрөнгийг нийт өөрийн хөрөнгийн дүнгээс хасна;

2.11.6. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийн 14 дүгээр зүйлээр тогтоосон хязгаарлалтыг давсан хэсгийн 75 хувийг нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс, үлдсэн 25 хувийг хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс хасна. Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө хүрэлцэхгүй бол нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс үлдсэн хэсгийг хасна.

2.12. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк Монголбанк, эрх бүхий байгууллагын шаардлага, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдалтай холбоотой залруулгын гүйлгээг зохих дансанд хийж өөрийн хөрөнгийн бодит дүнг гаргана.

2.13. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны эрсдэлээр жигнэсэн актив дараах бүрэлдэхүүнтэй байна:

- 2.13.1. Зээлийн эрсдэлээр жигнэсэн актив;
- 2.13.2. Гадаад валютын эрсдэлээр жигнэсэн актив;
- 2.13.3. Үйл ажиллагааны эрсдэлээр жигнэсэн актив.

2.14. Зээлийн эрсдэлээр жигнэсэн активын дүнг тооцохдоо тэнцлийн актив, тэнцлийн гадуурх хүлээж болзошгүй үүргийн дүнг энэ журмын 1 дүгээр хавсралтад тусгасан эрсдэлийн хувиар үржүүлж гаргах бөгөөд дараах зарчмыг баримтална:

2.14.1. Актив нь энэ журмын 1 дүгээр хавсралтад тусгасан нэгээс олон ангилалд хамаарч байгаа бол хамгийн өндөр эрсдэлийн жинтэй ангилалд хамааруулна;

2.14.2. Стандарт энд Пурс (Standard & Poors), Мүүдиз (Moody’s), Фич (Fitch) байгууллагаас тогтоосон зээлжих суурь (*baseline*)¹ зэрэглэлийг ашиглан гадаадын банкнаас авах авлагын эрсдэлийн хувь хэмжээг дараах хүснэгтийг үндэслэн тогтооно.

Стандарт энд Пурс	AAA / AA-	A+ / A-	BBB+ / BBB-	BB+ / B-	B- бага	Рейтинггүй банк
Фич						
Мүүдиз	Aaa/Aa3	A1/A3	Baa1/Baa3	Ba1/B3	B- бага	
3 сараас дээш хугацаатай авлага	20%	50%	50%	100%	150%	100%
3 сар хүртэл хугацаатай авлага	20%	20%	20%	50%	150%	100%

2.14.3. Энэ журмын 2.14.2-т заасан 2 болон түүнээс дээш зэрэглэл тогтоох байгууллагаас зээлжих зэрэглэл тогтоолгосон гадаадын банкнаас авах авлага болон түүний батлан даалтаар баталгаажсан зээлийн эрсдэлийн хувь хэмжээг тооцохдоо хамгийн доод зэрэглэлийг ашиглана.

2.15. Эрсдэлээр жигнэх тэнцлийн болон тэнцлийн гадуурх активын үлдэгдэлд дараах тохируулгыг хийнэ:

¹ “Baseline” үнэлгээгүй тохиолдолд хамгийн “Long term” үнэлгээг авна.

2.15.1. Актив нь Монгол Улсын Засгийн газрын баталгаа, олон улсын зээлжих зэрэглэлийг тогтоогч байгууллагын “А”-аас доошгүй үнэлгээ бүхий санхүүгийн байгууллагаас гаргасан баталгаа, батлан даалт, тэдгээртэй эрсдэл хуваах хэлцлээр баталгаажсан болн баталгааны дүнгийн 80 хувиар цэвэршүүлнэ;

2.15.2. Актив нь Дэлхийн банк, Олон улсын санхүүгийн корпораци, Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Азийн хөгжлийн банкнаас гаргасан баталгаа, батлан даалт, тэдгээртэй эрсдэл хуваах хэлцлээр баталгаажсан бол баталгааны дүнгээр цэвэршүүлнэ;

2.15.3. Актив нь дотоодын банк, Монгол Улсын Засгийн газраас үүсгэн байгуулсан Зээлийн батлан даалтын сантай эрсдэл хуваах нөхцөлтэй (*syndicated loans* гэх мэт) бол харгалзах дүнгээр тухайн банкны активыг цэвэршүүлж, эрсдэл хуваагч банкны активыг нэмэгдүүлнэ. Нэгдмэл ашиг сонирхолтой, холбоотой банкуудад энэ зохицуулалт хамаарахгүй;

2.15.4. Тухайн активд зориулж тусгайлан эрсдэлийн сангаар цэвэршүүлнэ;

2.15.5. Актив нь үл маргах журмаар цэвэршүүлэх нөхцөлтэй тухайн банканд байршуулсан санхүүгийн эх үүсвэр болон сорьцоор баталгаажсан алт, мөнгөн гулдмайгаар баталгаажсан бол харгалзах (spot) дүнгээр цэвэршүүлнэ.

2.16. Гадаад валютын ханшийн эрсдэлээр жигнэсэн активыг энэ журмын 4.3-т заасан нийт нээлттэй позицитай дүнгээр тодорхойлно.

2.17. Үйл ажиллагааны эрсдэлээр жигнэсэн активыг тухайн банкны сүүлийн гурван жилийн нийт орлогын дунджийн 1 хувийг түүнд тогтоосон өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцааны доод хэмжээний урвуугаар үржүүлэн тодорхойлно. Банк өдөр дутмын үйл ажиллагаанд үүсэж байгаа алдагдал, хохирлыг бүртгэнэ.

2.18. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ, эрсдэл даах чадварыг үнэлэхэд шаардлагатай мэдээллийг тухай бүр Монголбанканд хүргүүлнэ.

2.19. Монголбанк эдийн засгийн мөчлөг, санхүүгийн тогтолцоон дахь хамаарлыг нь харгалзан хөрөнгө оруулалтын төрөлжсөн банканд нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний доод шаардлага дээр нэмэгдэх нөөц интервалын шаардлага тогтоож болно. Нөөц интервалын шаардлага 6.5 хувиас ихгүй байна.

2.20. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ зохистой харьцааны доод хэмжээ болон тухайн банканд тогтоосон нөөц интервалын нийлбэрээс бага бол нөөц алдагдсанд тооцно.

2.21. Тухайн хөрөнгө оруулалтын төрөлжсөн банканд тогтоосон нөөц 50 хүртэл хувиар алдагдсан тохиолдолд орлого, ашиг, нөөцөө хамгаалах, эрсдэл даах чадварыг улам муутгах зарцуулалт хийхээс сэргийлэх зорилгоор банк дараах арга хэмжээг авна:

2.21.1. Хувьцаа буцаан худалдаж авахгүй;

2.21.2. Энгийн болон давуу эрхийн хувьцаанд ногдол ашиг хуваарилахгүй, бусад төрлийн төлөлт хийхгүй;

2.21.3. Төлөөлөн удирдах болон гүйцэтгэх удирдлагад олгох урамшуулал, бусад төрлийн гүйцэтгэлд суурилсан нэмэгдлийн 50-с илүү хувийг төлөхгүй;

2.21.4. Энэ журмын 2.8 дэх заалтыг хангасан хөрвөх эх үүсвэр болон 2.10 дахь

заалтыг хангасан хоёрдогч өглөгт хуваарийн дагуу эргэн төлөх төлбөрийн 50-с илүү хувийг төлөхгүй.

2.22. Тухайн хөрөнгө оруулалтын төрөлжсөн банканд тогтоосон нөөц 50 ба түүнээс илүү хувиар алдагдсан тохиолдолд орлого, ашиг, нөөцөө хамгаалж, эрсдэл даах болон төлбөрийн чадвараа хадгалах зорилгоор банк дараах арга хэмжээг авна:

2.22.1. Энэ журмын 2.21.1, 2.21.2 дахь заалтад тусгасан арга хэмжээ;

2.22.2. Төлөөлөн удирдах болон гүйцэтгэх удирдлагын цалин, түүнтэй адилтгах бусад хөнгөлөлт, нэмэгдлийг өсгөхгүй;

2.22.3. Төлөөлөн удирдах болон гүйцэтгэх удирдлагад олгох урамшуулал, бусад төрлийн гүйцэтгэлд суурилсан аливаа нэмэгдлийг олгохгүй;

2.22.4. Энэ журмын 2.8-2.10 дахь заалтыг хангасан хувьцаанд хөрвөх эх үүсвэр, хоёрдогч өглөгтэй холбоотой аливаа төлөлт хийхгүй.

2.23. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцаа алдагдсан бол банк дараах арга хэмжээг авна:

2.23.1. Энэ журмын 2.22-д заасан арга хэмжээ;

2.23.2. Төлөөлөн удирдах болон гүйцэтгэх удирдлагад цалин, түүнтэй адилтгах хөлс, бусад нэмэгдэл, дэмжлэг, хандив олгохгүй;

2.23.3. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны удирдлага хувьцаанд хөрвөх нөхцөлтэй эх үүсвэр (хоёрдогч өглөг)-ийг энгийн хувьцаанд хөрвөх арга хэмжээний бэлтгэлийг Компанийн тухай хууль, банкны дүрэм, бусад эрх зүйн актад нийцүүлэн яаралтай гүйцэтгэж, үр дүнг Монголбанк мэдээлнэ.

2.24. Хувьцаанд хөрвөх нөхцөлтэй эх үүсвэрийг (хоёрдогч өглөг)-ийг хувьцаанд хөрвүүлэхэд дараах дарааллыг баримтална:

2.24.1. Хувь нийлүүлэгч, холбогдох этгээдийн хувьцаанд хөрвөх эх үүсвэр (хоёрдогч өглөг)-ийг бүхэлд нь;

2.24.2. Энэ журмын 2.24.1-д тусгасан арга хэмжээ авсны дараа нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа хангагдаагүй бол бусад хөрөнгө оруулагчийн эх үүсвэр (хоёрдогч өглөг)-ийг хэсэгчлэн, эсвэл бүхэлд нь.

ГУРАВ.ХӨРВӨХ ЧАДВАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА

3.1. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны богино хугацаанд активаа хөрвүүлэх чадварыг бэхжүүлэх, хэмжих зорилгоор хөрвөх чадварын зохистой харьцааг тогтооно.

3.2. Энэ журмын 3.1-д заасан зохистой харьцааны доод хэмжээ 100 хувь байна.

3.3. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь тухайн банк эсхүл банкны системд үүссэн санхүүгийн хүндрэлийн үед хөрвөх чадварын зохистой харьцаа зөрчигдөх тохиолдолд хэрэгжүүлэх нөөц төлөвлөгөөтэй байна.

3.4. Хөрвөх чадварын зохистой харьцааг энэ журмын 3.5-д заасан түргэн борлогдох

хөрөнгийг энэ журмын 3.6-д заасны дагуу тохируулж, 3.7-д заасан цэвэр гарах мөнгөн урсгалд харьцуулан тооцно.

3.5. Түргэн борлогдох хөрөнгийн үлдэгдлийг дараах бүрэлдэхүүн бүхий нэг болон хоёрдугаар түвшний түргэн борлогдох хөрөнгийн бодит үнэ цэнийн нийлбэрээр тодорхойлно:

3.5.1. Нэгдүгээр түвшний түргэн борлогдох хөрөнгөд бэлэн мөнгө, Монголбанканд байршуулсан хөрөнгө, энэ журмын дагуу эрсдэлийн жинг нь 0 хувиар тооцох засгийн газар, төв банк, олон талт хөгжлийн банкны үнэт цаас болон тэдгээрт байршуулсан хөрөнгө, сорьцоор баталгаажсан алтан, мөнгөн гулдмай, Монгол Улсын Төв банкны үнэт цаас, Монгол Улсын Засгийн газрын үнэт цаас, Монгол Улсын Засгийн газрын баталгаа бүхий үнэт цаас багтана;

3.5.2. Хоёрдугаар түвшний түргэн борлогдох хөрөнгөд энэ журмын дагуу эрсдэлийн жинг нь 20 хувиар тооцох засгийн газар, төв банк, олон талт хөгжлийн банкны үнэт цаас болон тэдгээрт байршуулсан хөрөнгө, Стандарт энд Пурс (Standard & Poor's), Муудиз (Moody's), Фич (Fitch) байгууллагаас тогтоосон "А-"-аас доошгүй үнэлгээ бүхий компанийн өрийн хэрэгсэл багтана. Энэхүү хөрөнгийн үлдэгдэлд дараах бүрэлдэхүүн бүхий нэмэлт хоёрдугаар түвшний түргэн борлогдох хөрөнгийг оруулж болно:

3.5.2.1. Нэмэлт хоёрдугаар түвшний түргэн борлогдох хөрөнгөд бусад банкны ипотекийн зээлээр баталгаажсан бонд, Стандарт энд Пурс (Standard & Poor's), Муудиз (Moody's), Фич (Fitch) байгууллагаас тогтоосон "BBB-"-аас доошгүй үнэлгээ бүхий компанийн өрийн хэрэгсэл багтана.

3.6. Энэ журмын 3.5-д заасан түргэн борлогдох хөрөнгөд дараах тохируулгыг дараалуулан хийнэ:

3.6.1. Аливаа санхүүгийн хэлцлийн үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар барьцаалсан, байршуулсан түргэн борлогдох хөрөнгийг хасах;

3.6.2. Гэрээний үндсэн дээр хугацаа, хүүгийн хэмжээг тохироогүй, захиран зарцуулах эрх нь шилжин ирээгүй түргэн борлогдох хөрөнгийг хасах;

3.6.3. Замд яваа мөнгийг түргэн борлоход хөрөнгөөс хасах;

3.6.4. Энэ заалтад дурдсанаас бусад хэлбэр, нөхцөлөөр тухайн хөрөнгийг түргэн борлуулахыг хязгаарласан бол харгалзах дүнг хасах;

3.6.5. Хоёрдугаар түвшнийн түргэн борлогдох хөрөнгийн бодит үнэ цэнд 15 хувь, нэмэлт хоёрдугаар түвшнийн түргэн борлогдох хөрөнгийн бодит үнэ цэнд 50 хувийн хямдруулалт тус тус хийх;

3.6.6. Хоёрдугаар түвшний түргэн борлогдох хөрөнгийн нийт түргэн борлогдох хөрөнгөд эзлэх хувь 40-с их, нэмэлт хоёрдугаар түвшний түргэн борлогдох хөрөнгийн мөн үзүүлэлт 15-с их байх тохиолдолд харгалзах дүнг хасах;

3.7. Ирэх 30 хоногийн цэвэр гарах мөнгөн урсгалыг тус хугацаанд мөнгөн урсгал үүсгэхээр байгаа актив, пассивыг энэ журмын 3 дугаар хавсралтад заасан хувиар үржүүлж, тооцоолох бөгөөд доорх зарчмыг баримтална:

3.7.1. Орох, гарах мөнгөн урсгалын төсөөллийг санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдал бүхий сценарид тулгуурлан гүйцэтгэх бөгөөд сценарид аливаа хэрэгсэл, эд хөрөнгө,

хүлээж болзошгүй үүргийн бодит үнэ цэн, өөрийн болон харилцагчийн зээлжих зэрэглэл зэрэгт орж болзошгүй өөрчлөлтийг тусгана;

3.7.2. Санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдал бүхий сценарийн хүрээнд тухайн актив, пассивтай холбогдуулан ирэх 30 хоногийн турш аливаа мөнгөн урсгал үүсэхгүй, үүсэхээргүй бол цэвэр гарах мөнгөн урсгалын тооцоололд оруулахгүй;

3.7.3. Хүлээгдэж буй орох мөнгөн урсгал болон хүлээгдэж буй гарах мөнгөн урсгалыг 75 хувьд үржүүлсэн дүнгийн аль багыг цэвэр гарах мөнгөн урсгалын тооцоололд хэрэглэнэ;

3.7.4. Энэ журмын 3.5-д заасан түргэн борлогдох хөрөнгийн үлдэгдэлд оруулсан хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг тооцоололд оруулахгүй;

3.7.5. Нэг ижил актив, пассивыг орох, гарах мөнгөн урсгалын нэгээс дээш төрөлд давхар бүртгэж, тооцоололд оруулахгүй;

3.7.6. Нэг ижил харилцагчтай байгуулсан үүсмэл санхүүгийн хэрэгслийн орох, гарах мөнгөн урсгалыг үл маргах журмаар цэвэршүүлэх ерөнхий хэлцэл байгуулсан тохиолдолд цэвэршүүлсэн дүнгээр, бусад тохиолдолд тус тусад нь авч үзнэ;

3.7.7. Орох мөнгөн урсгалын тооцоололд зөвхөн хэвийн зээлтэй холбоотой мөнгөн урсгалыг харгалзаж үзнэ;

3.7.8. Бусад банк, санхүүгийн байгууллагаас авах авлага, санхүүжилтийг орох мөнгөн урсгалын тооцоололд оруулахгүй.

3.8. Монголбанкны шалгалтаар илрүүлсэн зөрчил, дутагдалтай холбоотой залруулгын гүйлгээг зохих дансанд хийж түргэн борлогдох хөрөнгийн бодит дүнг гаргана.

3.9. Банк хөрвөх чадвартаа иж бүрэн үнэлгээ, дүгнэлт өгч, стресс тест хийж, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зохистой харьцаа, эрсдэлийн удирдлагын зарчмыг дотооддоо мөрдөнө.

3.10. Банк, санхүүгийн байгууллагатай хийх тооцооны тайланг энэ журмын 4 дүгээр хавсралтын дагуу 7 хоног бүр тайлагнана.

3.11. Хөрвөх чадварын зохистой харьцааны биелэлтийг энэ журмын 2, 3 дугаар хавсралтын дагуу сар бүр, Монголбанк шаардсан тохиолдол 7 хоног бүр тайлагнана.

ДӨРӨВ.ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ЭРСДЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА

4.1. Гадаад валютын ханшийн хэлбэлзлээс үүсэж болзошгүй алдагдлыг хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны эрсдэл даах чадвартай уялдуулах зорилгоор тухайн нэг болон нийт гадаад валютын нээлттэй позицид хязгаарлалт тогтооно.

4.2. Тухайн нэг гадаад валютын нээлттэй позиц энэ журмын 2.11-т заасны дагуу тохируулсан 2.5-д тусгасан банкны өөрийн хөрөнгийн 15 хувиас хэтрэхгүй.

4.3. Нийт нээлттэй позицийг гадаад валют тус бүрийн хувьд тооцсон урт позицуудын нийлбэр болон богино позицуудын абсолют нийлбэрийн аль их дүн дээр цэвэршүүлсэн алт, мөнгөний нээлттэй позицийн абсолют дүнг нэмж тодорхойлох бөгөөд энэ журмын 2.11-д

заасны дагуу тохируулсан 2.5-д тусгасан банкны өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтрэхгүй.

4.4. Тухайн хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаа ханшийн зах зээлийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна гэж үзвэл тус банкны зохистой харьцааны хязгаарыг бууруулж болно.

4.5. Нэг гадаад валютын нээлттэй позицийг дараах үзүүлэлтүүдийн нийлбэрээр тооцож биелэлтийг энэ журмын 5 дугаар хавсралтын дагуу долоо хоног болон сар бүр ирүүлнэ:

4.5.1. Цэвэр спот позиц буюу тэнцлийн гадаад валютын актив, пассив, эх үүсвэрийн зөрүү (*үүнд хуримтлуулж тооцсон хүүг оруулан, цэвэршүүлсэн алт, мөнгөн гулдмайны үнэлгээг гаргахдаа тухайн үеийн спот ханшийг ашиглана, активын дүнгээс өөр валютаар сан байгуулсан валютын чанаргүй активыг хасна*);

4.5.2. Тайлант үеэс хойш 12 сарын дотор хэрэгжих Монголбанктай хийснээс бусад хэлцлээс үүдэлтэй гадаад валютын форвард, фьючерс болон свопын арилжаатай холбоотой авлага, өглөгийн зөрүү (*үүнд свопын хувьд спот арилжаатай холбоотой хэсгийг нь хасаж тооцох бөгөөд ирээдүйд орох, гарах мөнгөн урсгалыг спот ханшаар нь үнэлнэ*);

4.5.3. Тайлант үеэс хойш 6 сарын дотор хэрэгжих гадаад валютын баталгаа, батлан даалт, аккредитивын үүргийн сөрөг дүн. Ингэхдээ дараах тохируулгыг хийнэ:

4.5.3.1. Тооцоонд орсон баталгаа, батлан даалт, аккредитивын үүргийн ижил валютаарх эх үүсвэр нь тухайн банканд байршсан бол тэдгээрийг тооцооноос хасна;

4.5.3.2. Тооцоонд орсон баталгаа, батлан даалт, аккредитивын үүрэг нь ижил валютаар зээлийн шугамтай бол тэдгээрийг тооцооноос хасна.

4.5.4. Гадаад валютаар гаргасан бусад үүргийн сөрөг дүн;

4.5.5. Бусад үүрэг, гэрээ, хэлцлээр баталгаажсан гадаад валютын авлага, өглөгийн зөрүү;

4.5.6. Энэ журмын 7 дугаар хавсралтын дагуу тооцсон гадаад валютын опционы “дельта” суурьтай өртөг.

4.6. Монголбанк биелэгдэх боломжгүй гэж үзсэн гадаад валютын ирээдүйн өглөг, авлагыг нээлттэй позицийн тооцоонд оруулахгүй байж болно.

4.7. Монголбанктай хийсэн гадаад валютын бодит болон бодит бус деривативын авлага, өглөгийн дүнг хугацаанаас үл хамааран нээлттэй позицийн тооцоонд тусгаж болно.

4.8. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк ханшийн эрсдэлээс үүсэх алдагдлыг үнэлэхэд шаардлагатай бусад мэдээллийг тухай бүр Монголбанканд хүргүүлнэ.

ТАВ.ТӨВЛӨРЛИЙН ЭРСДЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА, ХЯЗГААРЛАЛТ

5.1. Төвлөрлийн эрсдэлийн зохистой харьцаа, Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан хязгаарлалтыг тооцоход ашиглах өөрийн хөрөнгө нь банкны нягтлан бодох бүртгэлийн багц материалын дагуу тодорхойлсон өөрийн хөрөнгө болон энэ журмын хүрээнд эрсдэл даах чадвартай гэж тооцогдсон эх үүсвэрийн нийлбэр байна.

5.2. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийн 14 дүгээр зүйлд зааснаас бусад, дараах хэлбэрээр хүлээх төвлөрлийн эрсдэлд энэ журмын 5.1-д тодорхойлсон өөрийн хөрөнгийн хувь бүхий дээд хязгаар дотооддоо тогтоон мөрдөнө:

5.2.1. Аливаа нэг харилцагч болон түүнтэй харилцан хамаарал бүхий этгээдүүдийн активаар;

5.2.2. Эдийн засгийн салбараар;

5.2.3. Барьцаа хөрөнгийн төрлөөр;

5.2.4. Санхүүгийн хэрэгслийн төрлөөр;

5.2.5. Бусад.

5.3. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк энэ журмын 5.2-т заасан эрсдэлийг тооцох, хангах, өөрийн үйл ажиллагааны онцлогтой уялдсан томоохон харилцагч, тэдгээрийн актив, эх үүсвэртэй холбогдох харилцааг зохицуулсан бодлого журамтай байна.

5.4. Монголбанк олон улсын сайн туршлага, дотоодын онцлог, үндэсний эдийн засгийн тогтвортой хөгжлийг харгалзан энэ журмын 5.3-т заасан хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны дотоод журмыг өөрчлөхийг тухайн банкнаас шаардаж болно.

5.5. Банкны салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор Монголбанк хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны бусад банкнаас татан төвлөрүүлэх эх үүсвэрийн үлдэгдэлд өөрийн хөрөнгийн хувь бүхий дээд хязгаар тогтоож болно.

5.6. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн биелэлтийг энэ журмын 8 дугаар хавсралтын дагуу сар бүр тайлагнана.

ЗУРГАА.ХЯНАЛТ, ТАЙЛАГНАЛ

6.1. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк энэ журамд тусгасан зохистой харьцаа, хязгаарлалтыг өдөр бүр хангаж ажиллана. Энэ журамд заасан зохистой харьцаа алдагдсан, хязгаарлалт зөрчигдсэн тохиолдолд Монголбанканд бичгээр, банк хариуцсан хянан шалгагчид (багийн ахлагчид) цахим шуудангаар тухай бүр мэдэгдэнэ.

6.2. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк зохистой харьцааны биелэлтийн болон Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад тайлан, мэдээ мэдээллийг дараа сарын 5-ны өдрийн дотор Монголбанканд бичгээр эсхүл цахим системээр ирүүлнэ.

6.3. Энэ журмын хэрэгжилтэд Монголбанк хяналт тавьж, хууль тогтоомжид заасан хяналт шалгалт, албадлагын арга хэмжээ авна.

МОНГОЛБАНК, САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ЖУРМЫН ТӨСӨЛ

Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон хязгаарлалтыг тогтоох, түүнд хяналт тавих журмын 1 дүгээр хавсралт

БАНКНЫ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ
ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ТАЙЛАН

Огноо

Сая төгрөгөөр

		Үзүүлэлт	Дүн
А. Өөрийн хөрөнгө /AI+AI/			
<i>I Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө (1+2+3+4+5-6)</i>			0.0
1	Энгийн хувьцаа		
2	Давуу эрхийн хувьцаа		
3	Энгийн хувьцаанаас нэмж төлөгдсөн капитал		
4	Давуу эрхийн хувьцаанаас нэмж төлөгдсөн капитал		
5	Хуримтлагдсан ашиг (алдагдал)		
6	Нөөц сан		
7	Тохируулга		
8	<i>Хасагдах (6.1+6.2+6.3)</i>		0.0
8.1	<i>Халаасны хувьцаа (энгийн болон давуу эрхийн хувьцаа)</i>		
8.2	<i>Гүүдвил</i>		
8.3	<i>Хойшлогдсон татварын авлага, програм хангамж</i>		
<i>II Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө (1+2+3+4+5-6)</i>			0.0
1	Хувьцаанд хөрвөх эх үүсвэр		
2	Хоёрдогч өглөг		
3	Тохируулга		
		Үзүүлэлт	Эрсдэлээр жигнэх хувь
Б. Эрсдэлээр жигнэсэн актив (I+II+III+IV)			-
I Тэнцлийн үзүүлэлт			-
1	Бэлэн мөнгө		0%
2	Замд яваа мөнгө		20%
3	Монгол Улсын Төвбанкнаас авах авлага, түүнд хуримтлуулсан хүү		0%
4	Дотоодын банкнаас авах авлага		-
4.1	3 сараас доош хугацаатай төгрөгийн авлага		20%

ЖУРМЫН ТӨСӨЛ

4.2	Бусад	100%
4.3	Хуримтлуулсан хүү	100%
5	Монгол Улсын Хөгжлийн банкнаас авах авлага	-
5.1	3 сараас доош хугацаатай төгрөгийн авлага	20%
5.2	Бусад	100%
5.3	Хуримтлуулсан хүү	100%
6	Монгол Улсын Хадгаламжийн даатгалын корпорациас авах авлага	100%
7	Дотоодын бусад санхүүгийн байгууллагаас авах авлага	100%
8	Гадаадын банк, санхүүгийн байгууллагуудаас авах авлага	-
8.1	3 сараас дээш хугацаатай	-
8.1.1	AA- дээш үнэлгээтэй гадаадын санхүүгийн байгууллага	20%
8.1.2	BBB-; A+ үнэлгээтэй гадаадын санхүүгийн байгууллага	50%
8.1.3	B-; BB+ үнэлгээтэй гадаадын санхүүгийн байгууллага	100%
8.1.4	B- бага үнэлгээтэй гадаадын санхүүгийн байгууллага	150%
8.2	3 сараас доош хугацаатай	-
8.2.1	BBB- дээш үнэлгээтэй гадаадын санхүүгийн байгууллага	20%
8.2.2	B-; BB+ үнэлгээтэй гадаадын санхүүгийн байгууллага	50%
8.2.3	B- бага үнэлгээтэй гадаадын санхүүгийн байгууллага	150%
8.3	Үнэлгээгүй гадаадын санхүүгийн байгууллага	100%
9	Төвбанкны үнэт цаас, хуримтлуулж тооцсон хүү (Монголбанк)	0%
10	Монгол Улсын Засгийн газрын үнэт цаас	-
10.1	Монгол Улсын Засгийн газрын үнэт цаас, хуримтлуулж тооцсон хүү	0%
10.2	Монгол Улсын Засгийн газрын баталгаатай үнэт цаас	0%
10.3	Монгол Улсын Засгийн газрын баталгаатай үнэт цаасны хуримтлуулж тооцсон хүү	100%
11	Гадаадын засгийн газар, төв банкны үнэт цаас, хуримтлуулж тооцсон хүү	-
11.1	AA- дээш үнэлгээтэй улс	0%
11.2	A+; A- үнэлгээтэй улс	20%
11.3	BBB+; BBB- үнэлгээтэй улс	50%
11.4	BB+; B- үнэлгээтэй улс	100%
11.5	B- доош үнэлгээтэй улс	150%
11.6	Үнэлгээгүй улс	100%
12	Дотоодын үнэт цаас	-
12.1	Хувьцаа, вексель, бусад	100%
12.2	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	-

ЖУРМЫН ТӨСӨЛ

12.2.1	Нэхэмжлэх эрх нь ялгаагүй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	100%
12.2.2	Нэхэмжлэх эрх нь ялгаатай хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	-
12.2.3.1	Хамгийн давуу эрхтэй хэсэг	100%
12.2.3.2	Бусад хэсэг	200%
12.2.4	МИК-ээс гаргасан ИЗЗБ	50%
12.3	Бусад үнэт цаас	100%
12.4	Хуримтлуулж тооцсон хүү	100%
13	Гадаадын үнэт цаас (<i>үнэт цаасны үнэлгээгээр</i>)	-
13.1	3 сараас дээш хугацаатай	-
13.1.1	AA- дээш үнэлгээтэй	20%
13.1.2	BBB-; A+ үнэлгээтэй	50%
13.1.3	B-; BB+ үнэлгээтэй	100%
13.1.4	B- бага үнэлгээтэй	150%
13.2	3 сараас доош хугацаатай	-
13.2.1	BBB- дээш үнэлгээтэй	20%
13.2.2	B-; BB+ үнэлгээтэй	50%
13.2.3	B- бага үнэлгээтэй	150%
13.3	Үнэлгээгүй	100%
14	Хараат болон охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	100%
15	Зээл	-
15.1	Ханшийн эрсдэлтэй этгээдэд олгосон гадаад валютын зээл”	150%
15.3	Бусад зээл	100%
15.4	Чанаргүй зээл (нягтлан бодох бүртгэлийн дагуу тогтоосон ангилал)	150%
15.5	Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	100%
16	Санхүүгийн хөрөнгө, хуримтлагдсан хүү	100%
17	Санхүүгийн бус хөрөнгө	-
17.1	Алт, мөнгөн гулдмай	0%
17.2	Бусад санхүүгийн бус хөрөнгө	100%
18	Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, борлуулах зориулалттай хөрөнгө	100%
19	Дериватив санхүүгийн хөрөнгө	100%
19.1	Монголбанктай байгуулсан свопын бодит үнэ цэнийн авлага	0%
II	Тэнцлийн гадуурх үзүүлэлт	
1	Деривативын зээлтэй адилтган тооцох өртөг (<i>10 дугаар хавсралтын дагуу</i>)	100%
2	Аккредитив	20%

ЖУРМЫН ТӨСӨЛ

3	Батлан даалт, баталгаа	100%
4	Тендер болон гүйцэтгэлийн батлан даалт	50%
5	Зээлийн шугам	50%
6	Хамтын санхүүжилттэй зээлийн эрсдэлд харгалзах зээлийн цэвэр үлдэгдэл	100%
7	Бусад хүлээж болох үүрэг	100%
III	Гадаад валютын эрсдлийн үзүүлэлт	
IV	Сүүлийн гурван жилийн эерэг нийт орлогын дундаж	
1	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцааны доод хэмжээ	9%
2	Өөрийн хөрөнгийн зохистой харьцааны доод хэмжээ	12%
3	Нөөц интервал	
4	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ биелэлт	
5	Өөрийн хөрөнгийн хүрэлцээний биелэлт	
6	Шаардлагатай нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө	
7	Шаардлагатай хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө	

Энэхүү тайланд активыг хугацаагаар нь ангилах бол үлдсэн хугацааг нь ашиглана.

“-Зээл, үнэт цаас, эдгээртэй адилтгах санхүүгийн хэрэгсэлд холбогдох гадаад валютаар төлөх нийт төлбөрийн дүн нь сүүлийн 2 жилийн татварын дараах нийт гадаад валютаарх орлогын дунджийн 85 хувиас их этгээдийг ханшийн эрсдэлтэй гэж үзнэ. Уг этгээд нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй банктэй ханшийн эрсдэлээс хамгаалах санхүүгийн үүсмэл хэрэгслийг зээлийн нийт хугацаанд байгуулсан бол ханшийн эрсдэлгүй гэж тооцно.

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал: /нэр/
 Санхүү, бүртгэлийн газрын захирал /нэр/
 Санхүү, бүртгэлийн газрын ажилтан /нэр/

ЖУРМЫН ТӨСӨЛ

Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон хязгаарлалтыг тогтоох, түүнд хяналт тавих журмын 2 дугаар хавсралт

ТҮРГЭН БОРЛОГДОХ ХӨРӨНГИЙН ТАЙЛАН

Огноо	Сая төгрөгөөр	
Түргэн борлогдох хөрөнгийн төрөл	Хямдруулах хувь хэмжээ	Утга
<i>А.Нэгдүгээр түвшний түргэн борлогдох хөрөнгө</i>		
1.Бэлэн мөнгө	0%	
2.Монголбанканд байршуулсан хөрөнгө		
3.Эрсдэлийн жин нь 0 хувиар тооцогдох засгийн газар, төв банк, олон талт хөгжлийн банкны үнэт цаас, тэдгээрт байршуулсан хөрөнгө		
4.Сорьцоор баталгаажсан алтан, мөнгөн гулдмай		
5.Монгол Улсын Төв банкны үнэт цаас		
6.Монгол Улсын Засгийн газрын үнэт цаас, баталгаатай үнэт цаас		
<i>Б.Хоёрдугаар түвшний түргэн борлогдох хөрөнгө</i>		
1.Эрсдэлийн жин нь 20 хувиар тооцогдох засгийн газар, төв банк, олон талт хөгжлийн банкны үнэт цаас, тэдгээрт байршуулсан хөрөнгө	15%	
2.Стандарт энд Пурс (Standard & Poor’s), Муудиз (Moody’s), Фич (Fitch) байгууллагаас тогтоосон “А”-аас доошгүй үнэлгээ бүхий компанийн өрийн хэрэгсэл багтана		
<i>В.Нэмэлт хоёрдугаар түвшний түргэн борлогдох хөрөнгө</i>		
1.Бусад банкны ипотекийн зээлээр баталгаажсан бонд	50%	
2.Стандарт энд Пурс (Standard & Poor’s), Муудиз (Moody’s), Фич (Fitch) байгууллагаас тогтоосон “BBB”-аас доошгүй үнэлгээ бүхий компанийн өрийн хэрэгсэл багтана		
НИЙТ ТҮРГЭН БОРЛОГДОХ ХӨРӨНГИЙН ҮЛДЭГДЭЛ:		

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал: /нэр/
 Санхүү, бүртгэлийн газрын захирал /нэр/
 Санхүү, бүртгэлийн газрын ажилтан /нэр/

Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон хязгаарлалтыг тогтоох, түүнд хяналт тавих журмын 3 дугаар хавсралт

ИРЭХ 30 ХОНОГИЙН ХУГАЦААНД
ОРОХ, ГАРАХ МӨНГӨН УРСГАЛЫН
ТӨСӨӨЛЛИЙН ТАЙЛАН

Огноо

Сая төгрөгөөр

Орох, гарах мөнгөн урсгалын төрөл	Фактор хувь	Утга
<i>А.Гарах мөнгөн урсгал</i>		
I.Хуулийн этгээдээс татан төвлөрүүлсэн, хөрөнгө барьцаалаагүй эх үүсвэр, өр төлбөр	xx	
1.Засгийн газар, төв банк, олон талт хөгжлийн банк, санхүүгийн бус компани, төрийн өмчит хуулийн этгээдээс татан төвлөрүүлсэн эх үүсвэр, өр төлбөр	40%	
2.Бусад эх үүсвэр, өр төлбөр	100%	
II.Барьцаа хөрөнгө бүхий эх үүсвэр, өр төлбөр	xx	
1.Төв банктай хийсэн, эсхүл нэгдүгээр түвшний түргэн борлогдох хөрөнгө барьцаалсан хэлцэл	0%	
2.Хоёрдугаар түвшний түргэн борлогдох хөрөнгө барьцаалсан хэлцэл (нэмэлт хоёрдугаар түвшний түргэн борлогдох хөрөнгийг үүнд оруулахгүй)	15%	
3.Монгол Улсын Засгийн газар, олон талт хөгжлийн банк, дотоодын төрийн өмчит хуулийн этгээдтэй хийсэн, нэг болон хоёрдугаар түвшний түргэн борлогдох хөрөнгөөс бусад хөрөнгө барьцаалсан хэлцэл	25%	
4.Нэмэлт хоёрдугаар түвшний түргэн борлогдох хөрөнгө барьцаалсан хэлцэл	50%	
5.Бусад хэлцэл	100%	
III.Нэмэлт шаардлага	xx	
1.Үүсмэл санхүүгийн хэрэгсэл болон бусад гэрээ, хэлцэлтэй холбогдуулан үүсэх нэмэлт санхүүжилтийн шаардлага	Санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдал бүхий сценарид үүсэх мөнгөн урсгалын дүнгээр	
2.Аливаа хэлцэлтэй холбогдуулан барьцаалуулах шаардлагатай хөрөнгө	100% 20% (барьцаа хөрөнгө нь нэгдүгээр түвшний түргэн борлогдох хөрөнгө бол)	
3.Хэрэглээгүй зээлийн шугам:	xx	
3.а.Иргэн, ЖДҮ-д нээсэн	5%	
3.б.Санхүүгийн бус компани, засгийн газар, төв банкны, олон талт	30%	

хөгжлийн банк, төрийн өмчит хуулийн этгээдэд нээсэн		
3.в.Банканд нээсэн	40%	
3.д.Бусад этгээдэд нээсэн	100%	
4.Хүлээж болзошгүй үүрэг:	хх	
4.а.Аккредитив	5%	
4.б.Бусад	100%	
5.Бусад	100%	
НИЙТ ГАРАХ МӨНГӨН УРСГАЛ:		
<i>Б.Орох мөнгөн урсгал</i>		
1.Барьцаа хөрөнгө бүхий зээл:	хх	
1.а.Нэгдүгээр түвшний түргэн борлогдох хөрөнгө барьцаалсан	0%	
1.б.Хоёрдугаар түвшний түргэн борлогдох хөрөнгө барьцаалсан (нэмэлт түвшний түргэн борлогдох хөрөнгө үүнд орохгүй)	15%	
1.в.Нэмэлт хоёрдугаар түвшний түргэн борлогдох хөрөнгө барьцаалсан	50%	
1.д.Бусад хөрөнгө барьцаалсан	100%	
2.Бусад этгээдээс батлан даасан дүн, нээсэн зээлийн шугам	0%	
3.Иргэдээс авах авлага	50%	
4.Санхүүгийн бус компаниас авах авлага	50%	
5.Санхүүгийн байгууллага, төв банкнаас авах авлага	100%	
НИЙТ ОРОХ МӨНГӨН УРСГАЛ:		
Цэвэр гарах мөнгөн урсгал = Гарах мөнгөн урсгал – Орох мөнгөн урсгал*		
Хөрвөх чадварын зохистой харьцаа = Нийт түргэн борлогдох хөрөнгө**/Цэвэр гарах мөнгөн урсгал		

*Энэ журмын 3.7.3-т заасан дүнгээр тооцно.

**Энэ журмын 3.6-д заасны дагуу тохируулсан, 3.5-д заасан түргэн борлогдох хөрөнгө.

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал: /нэр/

Санхүү, бүртгэлийн газрын захирал /нэр/

Санхүү, бүртгэлийн газрын ажилтан /нэр/

11	Богд	0.0	0.0								
II	Дотоодын санхүүгийн байгууллага	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1	Монголбанк	0.0	0.0								
2	Хөгжлийн банк	0.0	0.0								
3	Хадгаламжийн даатгалын ко	0.0	0.0								
4	ББСБ	0.0	0.0								
5	ХЗХ	0.0	0.0								
6	Бусад	0.0	0.0								
III	Гадаадын банк	0.0	0.0								
IV	Гадаадын санхүүгийн байгууллага	0.0	0.0								

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал:

/нэр/

Санхүү, бүртгэлийн газрын захирал

/нэр/

Санхүү, бүртгэлийн газрын ажилтан

/нэр/

	Баталгаа											
	Батлан даалт											
	Аккредитив											
	Бусад хүлээж болзошгүй үүрэг											
D	ГАДААД ВАЛЮТЫН НЭЭЛТТЭЙ ПОЗИЦИ											
E	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ (Саяаар, тухайн валютаар)											
F	ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (НЭГЖ ВАЛЮТААР)											
G	УРТ ПОЗИЦ (Тэрбум төгрөгөөр)											
H	БОГИНО ПОЗИЦ (Тэрбум төгрөгөөр)											
I	ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (НИЙТ)											
J	ХАМГИЙН ИХ ЭРСДЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ											
K	ХАМГИЙН ИХ ЭРСДЭЛ БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХАРЬЦАА											
	Ханш											

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал:

/нэр/

Санхүү, бүртгэлийн газрын захирал

/нэр/

Санхүү, бүртгэлийн газрын ажилтан

/нэр/

Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон хязгаарлалтыг тогтоох, түүнд хяналт тавих журмын 6 дугаар хавсралт

САНХҮҮГИЙН ДЕРИВАТИВИЙН ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАН ТООЦОХ ӨРТГИЙГ ТОДОРХОЙЛОХ АРГАЧЛАЛ

1. Санхүүгийн деривативийн зээлтэй адилтган тооцох өртгийг энэхүү аргачлалын дагуу тодорхойлно.
2. Зээлтэй адилтган тооцох өртгийг дараахь деривативийн хувьд тооцно:
 - 2.1. Хүүгийн эрсдэлийн деривативууд:
 - 2.1.1. Тухайн нэг улс, орны валютаар илэрхийлэгдсэн санхүүгийн хэрэгслүүдийн хүүг солилцох буюу своп хийх гэрээ, хэлцэл (Single currency interest rate swaps);
 - 2.1.2. Санхүүгийн хэрэгслүүдийн суурь хүүг солилцох буюу своп хийх гэрээ, хэлцэл (Basis swaps);
 - 2.1.3. Хүүгийн форвардын гэрээ, хэлцэл (Forward rate agreement);
 - 2.1.4. Худалдан авсан хүүгийн опцион гэрээ, хэлцэл. Үүнд хүүгийн дээд болон доод хязгаарыг тогтоосон, мөн эдгээрийг хослуулан хэрэглэсэн гэрээ, хэлцэл хамаарна (Interest rate options purchased, including caps, collars and floors purchased);
 - 2.2. Гадаад валютын арилжааны дериватив:
 - 2.2.1. Хоёр өөр улс орны валютаар илэрхийлэгдсэн санхүүгийн бүтээгдэхүүний хүүг солилцох буюу своп хийх гэрээ, хэлцэл (Cross-currency interest rate swaps);
 - 2.2.2. Гадаад валютын арилжааны форвардын гэрээ, хэлцэл (Forward foreign exchange contracts);
 - 2.2.3. Бусдаас худалдан авсан гадаад валютын арилжааны опцион гэрээ, хэлцэл (Currency options purchased).
 - 2.3. Зээлийн эрсдэл үүсгэж болзошгүй санхүүгийн бусад дериватив.
3. Энэхүү аргачлалын 2 дугаар хэсэгт заасан деривативийн ангилалд хамаарах боловч дараах шинж чанарыг агуулсан деривативийн хувьд зээлтэй адилтган тооцох өртгийг тооцох шаардлагагүй:
 - 3.1. Үлдсэн хугацаа нь 14 өдрөөс доош;
 - 3.2. Тусгай зориулалт бүхий дотоодын бирж дээр арилжаалдаг, үнэ ханшийн зөрүүнээс үүдэлтэй аливаа төлбөр тооцоог өдөрт нь тусгай клирингийн төвөөр дамжуулан гүйцэтгэдэг дериватив.

4. Санхүүгийн деривативийн зээлтэй адилтган тооцох өртгийг (credit equivalent amount) тухайн үеийн (current exposure) болон ирээдүйд хүлээж болзошгүй (potential future credit exposure) алдагдлын нийлбэр дүнгээр тодорхойлно.
5. Тухайн үеийн алдагдлын дүнг санхүүгийн деривативийн суурь бүтээгдэхүүний гэрээнд заасан үнэ болон тухайн үеийн зах зээлийн үнэ хоёрын зөрүүгээр тооцох бөгөөд шаардлагатай үед хүү, ханш, индекс болон харилцагч этгээдийн төлбөрийн чадварт гарсан өөрчлөлтийг харгалзан үзэж болно.
6. Ирээдүйд хүлээж болзошгүй алдагдлын дүнг санхүүгийн деривативийн суурь бүтээгдэхүүний гэрээнд заасан үнийг Базелийн банкны хяналт шалгалтын хорооноос баталсан хөрвүүлэлтийн хувь хэмжээгээр (conversion factor) үржүүлэн тооцно:

Төлөгдөх хугацаа	Хүүгийн эрсдэлийн	Гадаад валютын болон алтны арилжааны	Хувьцааны арилжааны	Алтнаас бусад үнэт металлын	Бусад
1 жилээс доош хугацаатай	0.0%	1.0%	6.0%	7.0%	10.0%
1-5 жилийн хугацаатай	0.5%	5.0%	8.0%	7.0%	12.0%
5 жилээс дээш хугацаатай	1.5%	7.5%	10.0%	8.0%	15.0%

7. Деривативийн ашиг, алдагдлыг цэвэршүүлэн тооцох боломжтой бол зээлтэй адилтган тооцох өртгийг дараахь томъёог ашиглан бодож гаргана:

$$A_{Net} = 0.4 \times A_{Gross} + 0.6 \times NGR \times A_{Gross}$$

A_{net} - зээлтэй адилтган тооцох цэвэр өртөг

A_{gross} - зээлтэй адилтган тооцох нийт өртөг

NGR – ашиг, алдагдлын нийлбэр дүнг тухайн үеийн алдагдлын нийлбэр дүнд харьцуулсан харьцаа. Үүнд ашиг, алдагдлын нийлбэр дүн нь тэгтэй тэнцүү, аль эсвэл сөрөг утгатай байвал NGR-ийг тэгтэй тэнцүү гэж үзнэ.

ЖИШЭЭ:

“А” банк нь 3 сарын хугацаатай, 5000.0 мянган ам.долларын гадаад валютын форвардын гэрээ; 4 жилийн хугацаатай, 6000.0 мянган ам.долларын суурь хүүгийн свопын гэрээ; 6 жилийн хугацаатай, 12000.0 мянган ам.долларын хувьцааны арилжааны фьючерсийн гэрээ тус тус байгуулсан байсан бөгөөд 2004 оны 4 дүгээр сарын байдлаар деривативуудыг зах зээлийн үнэлгээгээр нь үнэлэхэд гадаад валютын арилжааны гэрээнээс 20.0 мянган ам.долларын, хувьцааны арилжааны фьючерсийн гэрээнээс 100.0 мянган ам.долларын алдагдал тус тус хүлээж, харин хүүгийн свопоос 10.0 мянган ам.долларын ашиг олсон байв.

“А” банкны зээлтэй адилтган тооцох нийт өртгийг тооцоход:

2004 оны 4 дүгээр сарын байдлаар

(мянган ам.доллар)

	САНХҮҮГИЙН ДЕРИВАТИВ	Суурь бүтээгдэхүүний үнэ	Хөрвүүлэлтийн хувь хэмжээ	Ирээдүйд хүлээж болзошгүй алдагдал	Тухайн үеийн алдагдал	Зээлтэй адилтган тооцох өртөг (нийт)
	А	1	2	3=1*2	4	5=3+(4>0)
1	3 сарын хугацаатай гадаад валютын форвардын гэрээ	5 000,0	1,0%	50,0	20,0	70,0
2	4 жилийн хугацаатай суурь хүүгийн своп	6 000,0	0,5%	30,0	0,0	30,0*
3	6 жилийн хувьцааны арилжааны фьючерсийн гэрээ	12 000,0	10,0%	1 200,0	100,0	1300,0
	БҮГД	23 000,0		1 280,0	120,0	1400,0

Тайлбар: * - зээлтэй адилтган тооцох өртгийг тооцохдоо ирээдүйд хүлээж болзошгүй алдагдлын дүнг тухайн үеийн ашгийн дүнгээр хорогдуулахгүй.

Хүснэгтээс үзэхэд 3 деривативийн гэрээнийн зээлтэй адилтган тооцох нийт өртөг нь 1400.0 мянган ам.доллар байна. Хүүгийн свопын ашгийг харгалзан зээлтэй адилтган тооцох өртгийг тооцвол:

$$A_{Net} = 0.4 \times 1400.0 + 0.6 \times \left(\frac{20.0 - 10.0 + 100.0}{20.0 + 100.0} \right) \times 1400.0 = 1330.0$$

Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон хязгаарлалтыг тогтоох, түүнд хяналт тавих журмын 7 дугаар хавсралт

ГАДААД ВАЛЮТЫН ОПЦИОНЫ “ДЕЛЬТА” СУУРЬТАЙ ӨРТӨГ ТООЦОХ АРГАЧЛАЛТ

Гадаад валютын опционы “дельта” суурьтай өртгийг Гармэн-Колхаген ("Garman-Kohlhagen")-ны томъёогоор тооцно:

$$C = e^{-FT} SN(x + \sigma\sqrt{T}) - e^{-DT} KN(x)$$

$$x = \frac{\ln(S/K) + (D - F - \sigma^2/2)T}{\sigma\sqrt{T}}$$

$$delta = \frac{\partial C}{\partial S} = e^{-FT} N(x + \sigma\sqrt{T}) > 0$$

Үүнд “С” нь колл опционы өртөг, “F” нь гадаад валютын хүү, “D” нь үндэсний валютын хүү, “T” нь опционы хугацаа, “S” нь спот ханш, “K” нь опционы гэрээнд заасан ханш, N(x) нь спот болон гэрээнд заасан ханшны харьцааг хүүгийн зөрүү болон опционы хугацаагаар тохируулсан дүн нь тодорхой тоон утгатай тэнцүү буюу түүнээс бага байх магадлал. Энэхүү магадлалыг хэвийн тархалттай санамсаргүй хэмжигдэхүүний нягтын функцийг тусламжтайгаар олно.

Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон хязгаарлалтыг тогтоох, түүнд хяналт тавих журмын 8 дугаар хавсралт

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨРӨЛЖСӨН БАНКНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 14 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙН БИЕЛЭЛТ

Огноо

Сая төгрөгөөр

№	Биелэлтийг төрөл	Биелэлт”	Хасагдах дүн*	Тайлбар**
1	Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухайн хуулийн 14.1-ийн биелэлт			
2	Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухайн хуулийн 14.2-ийн биелэлт			
3	Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухайн хуулийн 14.3-ийн биелэлт			

“-Тийм, үгүй.

*-Энэ журмын 2.11.6-д заасны дагуу өөрийн хөрөнгийн хүрэлцээ тооцоход хасагдах дүн буюу хязгаарлалтаас давсан хэсэг.

** -Хязгаарлалтаас илүү гарсан тохиолдолд зээлдэгчийн нэр, нөхцөл шалтгааныг тодорхой бичнэ.

Тайланг үнэн зөв гаргасан:

Гүйцэтгэх захирал: /нэр/

Санхүү, бүртгэлийн газрын захирал /нэр/

Санхүү, бүртгэлийн газрын ажилтан /нэр/